## НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (Сая.төг) | Төсвийн Гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| 4.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | 4.1.3 | 4.1.3.1 Харилцаа холбоо, мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн төвтэй, ухаалаг үйлчилгээг үзүүлэх “Цахим засаглал хөтөлбөр” хэрэгжүүлнэ. | 2022-2024 | НМТГ | Нийслэлийн төсөв | 15,000.0 | Цахим засаглал төслийн хэрэгжилт 20%-д хүрсэн байна. | Цахим засаглал төслийн хэрэгжилт 50%-д хүрсэн байна. | 4,500.0 | - | Нийслэлийн харьяа байгууллагуудын үйл ажиллагаандаа ашиглаж буй мэдээллийн системийг дахин төлөвлөсний дагуу орчин үеийн ухаалаг дэвшилтэт систем нэвтрүүлэн “Нэг тархи-Нэгдсэн систем” улаанбаатар хотын цахим шилжилтийн төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэхээр 2022 оны 06 дугаар сарын 08-ний өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон “АЙ СИ ТИ ГРУПП” ХК нь хамтран ажиллах санамж бичиг байгуулсны дагуу “Нэг тархи-Нэгдсэн систем” төслийн хүрээнд 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө болон үйл ажиллагаа бүрийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/912 дугаар захирамжаар батлуулсан. 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, нийслэл хотын удирдлага, албан хаагчид, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд танилцуулсан бөгөөд нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Үндэсний технологийн тэргүүлэх 70 гаруй компани, 1000 гаруй монгол инженерүүдтэй хамтран боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ, | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | нийтийн тээвэр зэрэг салбаруудад 12 дэд төслийг дэвшилтэт технологийн шийдлийг нэвтрүүлж иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэх ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхээр хамтран ажиллаж байгаа бөгөөд төслүүдийн хэрэгжилтийн 90%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. | |
| | 4.1.1 | 4.1.1.3. Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулна. | | | | | | | | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ашигладаг "E-DOC" - Албан хэрэг хөтлөлт, архивын өдөр тутмын үйл ажиллагааг цахим хэлбэрт хөтлөн явуулах, хянах, удирдах, нэгдсэн арга зүйгээр хангах зорилгоор https://edoc.ulaanbaatar.mn/ системийг 2016 онд хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийг нэвтрүүлснээр нийслэлийн нутгийн захиргааны **1324** байгууллагын **28525** албан хаагч ашиглаж байгаа бөгөөд 2022 оны байдлаар **1,940,066** албан бичгийг цахимаар солилцож **2,565,275** цаасыг хэмнэсэн байна. Хувийн хэвшлийн байгууллагууд "СМАРТ ОФФИС": системээр дамжуулан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай тоон гарын үсгээр баталгаажсан албан бичгийг цахимаар илгээх, солилцох зорилгоор "Смарт оффис" системийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системд төрийн болон хувийн хэвшлийн **2349** байгууллага бүртгэгдэж албан бичгийг тоон гарын үсгээр 100% цахимаар солилцож байна. | 100% |
| | 4.1.1 | 4.1.1.4. Төрийн албан хаагчийн цахим боловсрол, хандлагыг сайжруулж, засаглалын уламжлалт үйл ажиллагаанд процессын дахин загварчлал хийнэ. | | | | | | | | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд процессын дахин загварчлал хийх хүрээнд нийслэлийн хэмжээнд үзүүлж буй нийт 589 төрлийн үйлчилгээнээс зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй 225 үйлчилгээнүүдийг үзүүлдэг бөгөөд нийслэлээс иргэн аж, ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрлөөс хамааран 10-12 төрлийн бичиг баримт бүрдүүлж, 8-10 шат дамжлагаар 12-20 орчим гарын үсэг зуруулж, 14-30 хоног зарцуулдаг. Тиймээс дээрх үйл ажиллагаанд процессын дахин загварчлал хийж | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | иргэн аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 74 төрлийн зөвшөөрлийн хүсэлтийг 100% цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр иргэн аж ахуйн нэгж байгууллага системд бүртгүүлсэний үндсэн дээр үйл ажиллагаагаа эрхлэх боломжтой болсон. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар тус системд нийт **277,733** иргэн, ААНБ хандаж **7,936** хүсэлтийг ирүүлснээс **6,144** иргэн, аж ахуй нэгж байгууллага цахимаар хүсэлтээ шийдвэрлүүлж үйл ажиллагаагаа эхлээд байна. | |
| Нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгоно. | 4.1.3 | 4.1.3.2 Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НМТГ | Нийслэлийн төсөв | 300.0 | Нийслэлийн хэмжээнд утасгүй сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан гэр хороолол амралт зугаалгын газар болон хүн ам ихээр цуглардаг бүсүүдэд интернет үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх техникийн даалгавар боловсруулагдаж, нэгдсэн байдлаар зохион байгуулах төлөвлөгөө гаргасан байна. | Алслагдсан гэр хорооллын нэн шаардлагатай 20 цэгийг интернэтийн утасгүй сүлжээнд холбосон байна. | 160.0 | - | Нийслэлийн хэмжээнд хүн ам ихээр төвлөрдөг номын сан, амралт зугаалгын бүсийн судалгаа гаргаж нийт 35 байршилд шинээр утасгүй интернетийн үйлчилгээг хүргэхээр тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг гаргасан. Үүнд: Богд хааны ордон музей, Гандантэгчилэн хийд, УБ төмөр замын буудал, Хүүхдийн урлан бүтээх төв, Жуковын хөшөө, музей, Монгол цэргийн музей, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Улсын төв номын сан, Улсын төв номын сангийн салбарууд, Налайх дүүргийн Соёлын ордон Багахангай дүүргийн соёлын ордон гэх мэт байршилд суурилуулах техникийн даалгавар боловсруулагдсан бөгөөд 2022 оны нийслэлийн төсөвт санал хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. Нийслэлийн өндөр хурдны нэгдсэн сүлжээнд нийслэлийн төр захиргааны байгууллагуудыг холбох ажил 2011 оноос үе шаттайгаар эхлүүлсэн бөгөөд нийслэлийн нутгийн захиргааны **19** байгууллага, төвийн Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар болон **162** хороод холбогдсон. Алслагдсан Багануур, Налайх, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар болон **30** хороодыг "Скайнэтворкс" ХХК-ний шилэн кабелийн урсгал түрээсээр холбож интернетийн утасгүй сүлжээгээр дамжуулан интернетийн үйлчилгээг үзүүлж байна. | 30% |
| 4.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, аж ахуйн тооцоот байгууллагуудын чиг үүргийн давхардал, үйл ажиллагааны хийдлийг арилгаж, захиргааны төвлөрлийг сааруулж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | 4.2.1 | 4.2.1.2 нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрлийн тоог цөөрүүлж, зөвшөөрөл олгох нөхцөл журмыг тодорхой ойлгомжтой болгон цахимжуулж, хяналт шалгалтыг цөөрүүлнэ. | 2021-2024 | НЗДТГ | Нийслэлийн төсөв | - | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэрэгжилт 5 хувьд хүрсэн байна. | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэрэгжилт 10 хувьд хүрсэн байна. | - | - | Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимжуулахаар "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд дүүргүүдийн худалдаа үйлчилгээний хэлтсээс иргэн, аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 83 нэр төрлийн зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг баримт, шат дамжлагыг багасган цахимжуулж 5 минутын дотор үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 275186 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 7810 хүсэлтийг ирүүлснээс 6061 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. Мөн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас олгодог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 29 тусгай зөвшөөрлийг цахимжуулж үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бэлэн болсон ба 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр иргэд олон нийтэд нээлттэй байршуулж хүсэлтийг хүлээн авч эхлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | 90% |
| Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хулгайлах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулж, камерын хяналтын нэгдсэн системийг байгуулан, гэмт хэргийн | 4.3.1 | 4.3.1.1 Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2022-2024 | НЗДТГ, НМТГ, НАЗХГ, ЗИХТЗИГ | Нийслэлийн төсөв | - | Нийслэлийн удирдлага, хяналт зохицуулалтын нэгдсэн системийн техникийн даалгавар боловсруулагдсан байна. | Нэгдсэн системийг байгуулах ажлын хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | - | - | Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн дэд систем болох "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийн нэгдсэн систем"-ийн хөгжүүлэлтийн ажил дууссан бөгөөд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын тайлан мэдээ болон хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд систем ашиглалтын сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн албан хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон. | 90% |
| | 4.3.1 | 4.3.1.2 Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах | 2022-2024 | НЗДТГ, НМТГ | Нийслэлийн төсөв | - | Телекамер, замын хөдөлгөөний удирдлагын системийн | 1,415 камер холбосон байна. | - | - | Нийслэлийн хэмжээнд 2019 - 2021 онуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 7.2 тэрбум төгрөгийн 920 цэгийн 2240 камерын 71 ширхэг техникийн | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| гаралтыг бууруулна. | | өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглалыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, камерыг “Камерын удирдлагын нэгдсэн төв”-тэй холбоно. | | | | | техникийн даалгавар боловсруулагдсан байна. | | | | даалгавар, шийдлийг нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлсэн. Үүнээс 737 камерыг хүлээн авч Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын төвийн нэгдсэн камерын системд холбосон.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар 1000 камер суурилуулах 24 ширхэг камерын техникийн даалгаврыг боловсруулж хүргүүлсэн ба нийт 232 камерыг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын төвийн нэгдсэн камерын системд холбохоор төлөвлөн ажиллаж байна. | |
| **ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| 6.3 Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем төслийг бүрэн хэрэгжүүлнэ. | 6.3.11 | 6.3.11.3 Замын хөдөлгөөнийг удирдах, хянах, бүртгэх, үйл ажиллагааны нэгдсэн ухаалаг дэд системүүдийг нэвтрүүлнэ. | 2020-2024 | НМТГ, ЗХУТ, НЗХТЗИГ, НХБХГ, НГЗБА | Нийслэлийн төсөв | - | Нэгдсэн систем, дэд системүүдийн техникийн даалгавар боловсруулагдсан байна. | Дэд системүүдийн хөгжүүлэлтийн ажил 25 хувьд хүрсэн байна. | | 1,043,696,260 | Замын хөдөлгөөнийг удирдах, хянах, бүртгэх үйл ажиллагааны нэгдсэн ухаалаг систем нь дараахь дэд системүүдээс бүрдэнэ. Үүнд.<br>1. Нийслэлийн шалган нэвтрүүлэх 4 товчоод /Баруун түрүүн, Налайх Тэрэлж, Түргэний гол, Эмээлт/-ын төлбөр авах цэгт цахим төлбөрийн системийг 2022 оны 11 дүгээр сарын 01-нээс хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус төлбөрийн систем нь шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтэрч буй тээврийн хэрэгслийн дугаараар төлбөрийн нэхэмжлэлх үүсэх бөгөөд тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний Smartcar.mn систем болон аппликейшн, цахим банкаараа нэвтрэн төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлсэн. Систем нэвтэрснээс хойш шалган нэвтрүүлэх товчоодоор дамжин Улаанбаатар хот руу нэвтэрсэн нийт тээврийн хэрэгслийн тоо 361,094 бөгөөд төлбөр авах цэгээр нэвтэрч нэхэмжлэх үүссэн төлбөрийн дүн 6,197,5000 байна.<br>2. Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний https://smartcar.mn/ системд тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын мэдээлэл авах үйлчилгээ, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг мэдээлэх | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | үйлчилгээ, засвартай болон түр хаасан замыг мэдээлэх үйлчилгээ, хэтэвч цэнэглэх үйлчилгээ, хот хоорондын зам ашигласны хураамж төлөх, зогсоолын төлбөр төлөх үйлчилгээ болон замын хөдөлгөөний дүрмийн мэдээллийн санг бий болгож, Front-office болон back office системийн шинэчилсэн хувилбарын хэрэглээнд нэвтрүүлсэн. | |
| Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнөөс байгууллагад хамаарах 2 зорилтын 8 заалт, арга хэмжээний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар:<br>100 хувьтай хэрэгжсэн **4** арга хэмжээ,<br>90 хувьтай хэрэгсэн **2** арга хэмжээ<br>70 хувьтай хэрэгжсэн **1** арга хэмжээ<br>30 хувьтай 1 арга хэмжээ байна. **ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ:85 %** | | | | | | | | | | | | **85%** |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.САЙНХҮҮ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Т.ОТГОНЖАРГАЛ

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ 2022 ОНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

| Дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| 4.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | | | | | | | |
| **ЗДҮАХ 4.1.1.3** | Тоон гарын үсгийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулалт | хувь | НЗДТГ | - | 70 | 100 | 100% |
| **ЗДҮАХ 4.1.1.4** | Төрийн албан хаагчийн цахим боловсрол, хандлагыг сайжруулж, засаглалын уламжлалт үйл ажиллагаанд процессын дахин загварчлал хийнэ. | хувь | НЗДТГ | - | 70 | 100 | 100% |
| **ЗДҮАХ 4.1.3.1** | "Цахим засаглал" төслийн хэрэгжилт | хувь | НЗДТГ НМТГ | 20 | 50 | 50 | 100% |
| **ЗДҮАХ 4.1.3.2** | Алслагдсан гэр хороололд утасгүй интернэтийн сүлжээнд холбосон цэг | тоо | НМТГ | 154 | 174 | 30 | 30% |
| 4.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | | |
| **ЗДҮАХ 4.2.1.2** | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахимжуулалт | хувь | НЗДТГ НМТГ | 0 | 10 | 10% | 100% |
| 4.3 Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | | | | | | | |
| **ЗДҮАХ 4.3.1.1** | Нэгдсэн систем байгуулах ажлын хэрэгжилт | хувь | НЦУГ НМТГ | 18 | 30 | 90% | 90% |
| **ЗДҮАХ 4.3.1.2** | Удирдлагын нэгдсэн төвд холбогдсон камер | тоо | НЦУГ НМТГ | 415 | 1,415 | Нийслэлийн хэмжээнд 2019 - 2021 онуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 7.2 тэрбум төгрөгийн 920 цэгийн 2240 камерын 71 ширхэг техникийн даалгавар, шийдлийг нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлсэн. Үүнээс 737 камерыг хүлээн авч Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын төвийн нэгдсэн камерын системд холбосон. 2022 оны жилийн эцсийн байдлаар 1000 камер суурилуулах 24 ширхэг камерын техникийн даалгаврыг боловсруулж хүргүүлсэн ба нийт 232 камерыг Мэдээлэл, дүн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээ, шуурхай удирдлагын төвийн нэгдсэн камерын системд холбохоор төлөвлөн ажиллаж байна. | |
| **ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| 6.3 Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| **ЗДҮАХ 6.3.11.3** | Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг системд хамрагдалтын хувь | Хувь | НЗХТЗИГ<br>НМТГ<br>ЗХУТ | - | 25 | Төслийн нэвтрүүлэлтийн бэлтгэл ажил 90 хувьтай үргэлжилж байна. | 100% |
| Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнөөс байгууллагад хамаарах 2 зорилтын 8 заалт, арга хэмжээний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар:<br>100 хувьтай хэрэгжсэн **4** арга хэмжээ,<br>90 хувьтай хэрэгсэн **2** арга хэмжээ<br>70 хувьтай хэрэгжсэн **1** арга хэмжээ<br>30 хувьтай **1** арга хэмжээ байна. **ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ: 85%** | | | | | | | **85%** |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.САЙНХҮҮ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Т.ОТГОНЖАРГАЛ